



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 680.

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 10 нэрийн, нийт 16,207,419.91 (арван зургаан сая хоёр зуун долоон мянга дөрвөн зуун арван есөн төгрөг ерэн нэг мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 1,280,000.00 (нэг сая хоёр зуун наян мянга) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлайд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны дугаар сарын өдрийн
680 дугаар тогтоолын хавсралт

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГӨЛТӨЙ,
ҮНЭ ШИНЭЧЛЭН ТОГТООХ, АШИГЛАЛТЫН ХУГАЦАА СУНГАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ, хугацаа		
						Цаашид ашиглах жил	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Хэмжигч багаж /Total stashion sokkia/	2017-06-28	ш	3	12,257,000.00	1	300,000.00	900,000.00
2	Өлгөдөг тумбочка	2017-06-29	ш	10	1,125,995.80	1	20,000.00	200,000.00
3	Бичгийн ширээ шар	2017-06-29	ш	1	149,947.17	1	20,000.00	20,000.00
4	Онгорхой номын шүүгээ	2017-06-29	ш	2	208,640.00	1	20,000.00	40,000.00
5	Сандал	2017-06-29	ш	1	135,208.50	1	10,000.00	10,000.00
6	Сандал дугуйтай торон	2017-06-29	ш	1	148,313.70	1	10,000.00	10,000.00
7	Сандал цэнхэр торон C008-3	2017-06-29	ш	2	270,547.40	1	10,000.00	20,000.00
8	Туслах тумбочка ХБ	2017-06-29	ш	1	64,533.34	1	20,000.00	20,000.00
9	Файл шүүгээ ХБ	2017-06-29	ш	2	502,500.00	1	20,000.00	40,000.00
10	Хурлын дугуй ширээ	2017-06-29		1	1,344,734.00	1	20,000.00	20,000.00
ДҮН					16,207,419.91 (арван зургаан сая хоёр зуун долоон мянга дөрвөн зуун арван есөн төгрөг ерэн нэг мөнгө)			1,280,000.00 (нэг сая хоёр зуун наян мянга төгрөг)